

Дундговь аймгийн Засаг дарга Цахим хөгжлийн яамны сайдтай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 23

Мандалговь хот

## НЭГ.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Цахим хөгжлийн яамны сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр үүргийг хүлээж, жилийн эцсийн байдлаар 99.4 хувьтай хэрэгжүүлсэн байна.

## ХОЁР.ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.

Сумдын Засаг дарга, агентлагийн дарга нартай байгуулсан гэрээнд “Төрийн цахим үйлчилгээний “E-Mongolia” платформыг иргэдэд сурталчлах, “И-Монголиа” төрийн үйлчилгээний операторын үйл ажиллагааг дэмжин ажиллаж, цахим төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх” гэсэн 2 арга хэмжээг тусгаж, хэрэгжилт 90 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн. Төрийн албан хаагч бүр өөрийн ажлын төлөвлөлтдөө төрийн цахим үйлчилгээний нэгдсэн “E-Mongolia” платформыг сурталчлах ажлыг оруулан үр дүнг тооцож ажиллах чиглэлийг аймгийн Засаг даргаас өгч, мөн аймгийн Засаг даргын Тамгын газарт “И-Монголиа” төрийн үйлчилгээний төвийг шинээр байгуулан иргэдэд цахим төрийн үйлчилгээ үзүүлэх, олон нийт, аж ахуйн нэгжид мэдээлэл сурталчилгаа хийх, иргэдэд заавар зөвлөмж өгч цахим төрийн үйлчилгээг нэмэгдүүлэн ажиллах чиг үүрэг бүхий ажлын байр шинээр бий болгон ажиллуулсны үр дүнд аймгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний “E-Mongolia” хэрэглэгчдийн тоо: 2021 онд 11486 байсан бол 2022 онд 16223 болж өмнөх оноос 4737 иргэнээр өссөн үзүүлэлттэй байна.







2022 оныг “Хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, 2022 оныг “хүний хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, төрийн албан хаагч болон иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэсэн сургалт, арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.




Мэдээллийн “Dundgovi”, Санал хүсэлтийн “Дундговь” 2 аппликейшныг хэрэглээнд нэвтрүүлж иргэд санал хүсэлтээ цахимаар ирүүлэх боломжийг бүрдүүлсэн.





Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 бүлэг 64 төрөл, Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн төрийн байгууллагуудын нэгдсэн цахим хуудас [dundgovi.gov.mn](http://dundgovi.gov.mn)-ийг шинэчлэн сайжруулж ил тод нээлттэй мэдээлэл оруулах боломж бүрдүүлсэн. Мөн дээрх зорилтын хүрээнд аймгийн 15 буюу бүх сум өөрийн мэдээллийг удирдан оруулах, мэдээллийн ил тод байдлыг хангасан цахим хуудсыг шинээр бий болгож иргэдэд мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэх боломжоор хангасан. Цахим хуудасны мэдээллийг шуурхай, тогтмол оруулж байх боломжийг бүрдүүлэн цахим хуудсанд мэдээлэл оруулах эрхийг олгосноор тухай бүр мэдээллийн чанар, стандартын дагуу оруулж мэдээллийг иргэдэд түргэн шуурхай хүргэх боломж бүрдсэн. 2022 онд аймгийн цахим хуудасны мэдээ, мэдээлэл нийт 1112 мэдээ нийтлэгдсэнээс цагийн үеийн 357, төрийн байгууллагуудын 345, сумдын 191, зарлалын шинжтэй-80, фото-26, видео мэдээ-95 нийтлэгдсэн. 2022 онд сайтын хандалт 30960 байна.



## ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Төрийн албан хаагчдад тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулах Тоон гарын үсгийг бүртгэлийн 16 нэгжээр дамжуулан олгож байгаа бөгөөд 16-аас дээш насны 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос өнөөдрийн байдлаар 10982 иргэн буюу 34.0 хувьд олгоод байна. Тоон гарын үсгийг 9753 иргэнд иргэний үнэмлэхийн

чипэнд, 1129 иргэнд гар утасны gsign app-аар дамжуулан олгосон нь суурь түвшиндээ хүрээгүй байна.

## **ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ**

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Цахим хөгжлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 99.4 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.

Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга

Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын

албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Д.Даариймаа

Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний

хэлтсийн ахлах мэргэжилтэн

Э.Одончимэг